



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цахир сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/121/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn Аудитор Н.Энхчимэг Утас: 703333019 Цахим хаяг: Enkhchimeg@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	Error! Bookmark not defined.
4. Аудитын илрүүлэлт	Error! Bookmark not defined.
4.1 Залруулсан алдаа	Error! Bookmark not defined.
4.2 Албан шаардлага	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

ЦАХИР СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА
С.БАТСАЙХАН ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Цахир сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Цахир сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд Сумын Засаг даргын тамгын газрын дансанд бүртгэлтэй байсан 319 толгой малыг нэр бүхий иргэнтэй гэрээ байгуулан худалдан борлуулж 42.3 сая төгрөгийн авлага үүсгэсэн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	159,728,626.00	178,232,196.00
2	АВЛАГА	166,900.00	42,250,000.00
3	Ажиллагчидтай холбогдсон авлага	166,900.00	0
4	Бусад авлага	0	42,250,000.00
5	Хувь хүмүүсээс авах авлага	0	42,250,000.00
6	БАРАА МАТЕРИАЛ	159,561,726.00	96,690,196.00
7	Түүхий эд материал	7,497,700.00	4,205,500.00
8	Тусгай зориулалттай материал	7,497,700.00	4,205,500.00
9	Хангамжийн материал	6,211,026.00	8,334,696.00
10	Бичиг хэргийн материал	1,480,125.00	3,436,095.00
11	Аж ахуйн материал	4,730,901.00	4,898,601.00
12	Мал амьтад	145,853,000.00	84,150,000.00
13	НӨӨЦИЙН БАРАА	0	39,292,000.00
14	Тэжээлийн нөөц	0	39,292,000.00
15	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,237,031,230.18	1,557,308,599.33
16	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,237,031,230.18	1,557,308,599.33
17	Биет хөрөнгө	1,119,476,380.05	1,439,907,638.05
18	Барилга, байгууламж, орон сууц	390,926,774.00	389,421,110.00
19	Хуримтлагдсан элэгдэл	-33,954,655.08	-49,104,259.32
20	Авто-тээврийн хэрэгсэл	128,675,815.00	128,675,815.00
21	Хуримтлагдсан элэгдэл	-29,205,752.28	-47,396,872.32
22	Машин тоног төхөөрөмж(компьютер)	207,233,396.34	215,441,696.34
23	Хуримтлагдсан элэгдэл	-93,738,085.71	-85,886,209.04
24	Тавилга, аж ахуйн эд хогшил	66,295,077.77	66,875,177.77
25	Хуримтлагдсан элэгдэл	-28,619,769.36	-32,939,880.22
26	Зам, гүүрийн байгууламж	320,626,556.00	420,626,556.00
27	Хуримтлагдсан элэгдэл	-233,160,969.90	-12,109,797.66
28	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	204,190,000.00	204,190,000.00
29	Бусад үндсэн хөрөнгө	274,805,931.00	318,707,965.00
30	Хуримтлагдсан элэгдэл	-68,739,251.73	-90,734,977.50
31	Дуусаагүй барилга, байгууламж	14,141,314.00	14,141,314.00
32	Биет бус хөрөнгө	117,554,850.13	117,400,961.28
33	Програм хангамж	3,750,000.00	4,250,000.00
34	Хуримтлагдсан элэгдэл	-1,753,149.87	-2,407,038.72
35	Бусад биет бус хөрөнгө	115,558,000.00	115,558,000.00
36	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,396,759,856.18	1,735,540,795.33
37	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	263,560.00
38	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	263,560.00
39	Өглөг	0	263,560.00
40	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0	263,560.00
41	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,396,759,856.18	1,735,277,235.33
42	Засгийн газрын хувь оролцоо	1,396,759,856.18	1,735,277,235.33
43	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	445,966,870.17	445,966,870.17
44	Хуримтлагдсан үр дүн	842,343,682.39	1,180,861,061.54
45	Өмнөх үеийн үр дүн	696,007,722.32	842,343,682.39
46	Тайлант үеийн үр дүн	146,335,960.07	338,517,379.15
47	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	108,449,303.62	108,449,303.62
48	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,396,759,856.18	1,735,540,795.33

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	763,130,895.94	1,036,581,381.00
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	388,009,879.94	591,066,600.00
3	Нийтлэг татварын бус орлого	388,009,879.94	591,066,600.00
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	388,009,879.94	69,050,330.00
5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	47,738,100.00	69,050,330.00
6	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	340,271,779.94	0
7	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0	408,664,270.00
8	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	113,352,000.00
9	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	375,121,016.00	445,514,781.00
10	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,270,716.00	20,568,681.00
11	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0	4,820,000.00
12	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,270,716.00	15,748,681.00
13	Орон нутгийн төсвөөс санхүүжих	366,850,300.00	424,946,100.00
14	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	366,850,300.00	424,946,100.00
15	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	536,511,138.68	683,653,016.68
16	УРСГАЛ ЗАРДАЛ	536,511,138.68	683,653,016.68
17	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	475,245,662.05	584,649,415.85
18	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224,935,800.00	232,790,712.00
19	Үндсэн цалин	224,935,800.00	232,790,712.00
20	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,628,516.37	30,218,250.17
21	Тэтгэврийн даатгал	20,612,716.37	20,900,650.17
22	Тэтгэмжийн даатгал	2,205,300.00	2,329,400.00
23	ҮОМШӨ-ний даатгал	1,764,200.00	1,863,500.00
24	Ажилгүйдлийн даатгал	441,200.00	465,900.00
25	Эрүүл мэндийн даатгал	4,605,100.00	4,658,800.00
26	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,998,201.00	15,322,733.00
27	Гэрэл, цахилгаан	3,506,491.00	3,222,733.00
28	Түлш, халаалт	8,491,710.00	12,100,000.00
29	Хангамж, бараа материалын зардал	65,179,878.00	32,579,500.00
30	Бичиг хэрэг	3,545,000.00	5,174,530.00
31	Тээвэр, шатахуун	17,924,708.00	20,049,460.00
32	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,670,000.00	3,562,410.00
33	Ном, хэвлэл	120,000.00	60,000.00
34	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,001,570.00	1,161,300.00
35	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,180,000.00	2,571,800.00
36	Бараа материал акталсны зардал	35,738,600.00	0
37	Нормативт зардал	4,500,000.00	5,116,800.00
38	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,500,000.00	5,116,800.00
39	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	5,420,000.00
40	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	2,700,000.00
41	Урсгал засвар	0	2,720,000.00
42	Томилолт, зочны зардал	6,035,000.00	6,500,000.00
43	Дотоод албан томилолт	6,035,000.00	4,500,000.00
44	Зочин төлөөлөгч хүлээн авах	0	2,000,000.00
45	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,516,964.00	9,865,795.00
46	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,847,194.00	8,654,767.00
47	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	452,000.00	700,000.00

Архангай аймгийн Цахир сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

48	Даатгалын үйлчилгээ	0	54,450.00
49	Тээврийн хэрэгслийн татвар	134,920.00	108,310.00
50	Тээврийн хэрэгслийн оношлогоо	82,850.00	0
51	Газрын төлбөр	0	348,268.00
52	Бараа үйлчилгээний бусад зардал	115,451,302.68	246,835,625.68
53	Бараа үйлчилгээний бусад зардал	25,744,080.00	148,350,710.00
54	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,042,700.00	0
55	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	87,664,522.68	98,484,915.68
56	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,265,476.63	99,003,600.83
57	Бусад урсгал шилжүүлэг	18,864,100.00	700,000.00
58	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,539,100.00	0
59	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,325,000.00	700,000.00
60	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	42,401,376.63	98,303,600.83
61	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,401,376.63	98,303,600.83
62	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	226,619,757.26	352,928,364.32
63	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	80,283,797.19	14,410,985.17
64	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	30,483,797.19	457,485.17
65	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	49,800,000.00	13,953,500.00
66	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	146,335,960.07	338,517,379.15

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	445,966,870.17	108,449,303.62	696,007,722.32	1,250,423,896.11
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	445,966,870.17	108,449,303.62	696,007,722.32	1,250,423,896.11
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	146,335,960.07	146,335,960.07
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	445,966,870.17	108,449,303.62	842,343,682.39	1,396,759,856.18
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	445,966,870.17	108,449,303.62	842,343,682.39	1,396,759,856.18
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	445,966,870.17	108,449,303.62	842,343,682.39	1,396,759,856.18
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	338,517,379.15	338,517,379.15
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	445,966,870.17	108,449,303.62	1,180,861,061.54	1,735,277,235.33

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	422,859,116.00	514,565,111.00
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,738,100.00	69,050,330.00
3	Нийтлэг татварын бус орлого	47,738,100.00	69,050,330.00
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	47,738,100.00	69,050,330.00
5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	47,738,100.00	69,050,330.00
6	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	375,121,016.00	445,514,781.00
7	Нэмэлт санхүүжилтийн орлого	8,270,716.00	20,568,681.00
8	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0	4,820,000.00
9	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,270,716.00	15,748,681.00
10	Орон нутгийн төсвөөс санхүүжих	366,850,300.00	424,946,100.00
11	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	366,850,300.00	424,946,100.00
12	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	418,409,116.00	504,009,611.00
13	УРСГАЛ ЗАРДАЛ	418,409,116.00	504,009,611.00
14	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	357,143,639.37	405,006,010.17
15	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224,935,800.00	232,790,712.00
16	Үндсэн цалин	224,935,800.00	232,790,712.00
17	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,794,616.37	30,051,350.17
18	Тэтгэврийн даатгал	20,778,816.37	20,733,750.17
19	Тэтгэмжийн даатгал	2,205,300.00	2,329,400.00
20	ҮОМШӨ-ний даатгал	1,764,200.00	1,863,500.00
21	Ажилгүйдлийн даатгал	441,200.00	465,900.00
22	Эрүүл мэндийн даатгал	4,605,100.00	4,658,800.00
23	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,998,201.00	15,322,733.00
24	Гэрэл, цахилгаан	3,160,000.00	3,222,733.00
25	Түлш, халаалт	8,838,201.00	12,100,000.00
26	Хангамж, бараа материалын зардал	29,699,708.00	34,597,190.00
27	Бичиг хэрэг	3,804,500.00	5,045,400.00
28	Тээвэр, шатахуун	17,925,208.00	20,592,840.00
29	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,670,000.00	3,298,950.00
30	Ном, хэвлэл	120,000.00	60,000.00
31	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	2,800,000.00
32	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,180,000.00	2,800,000.00
33	Нормативт зардал	4,500,000.00	5,196,800.00
34	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,500,000.00	5,196,800.00
35	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	5,220,000.00
36	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	2,500,000.00
37	Урсгал засвар	0	2,720,000.00
38	Томилот, зочны зардал	6,035,000.00	6,500,000.00
39	Дотоод албан томилот	6,035,000.00	4,500,000.00
40	Зочин төлөөлөгч хүлээн авах	0	2,000,000.00
41	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,516,964.00	10,272,405.00
42	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,847,194.00	9,061,377.00
43	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	452,000.00	700,000.00
44	Даатгалын үйлчилгээ	0	54,450.00
45	Тээврийн хэрэгслийн татвар	134,920.00	108,310.00
46	Тээврийн хэрэгслийн оношлогоо	82,850.00	0
47	Газрын төлбөр	0	348,268.00
48	Бараа үйлчилгээний бусад зардал	32,663,350.00	65,054,820.00
49	Бараа үйлчилгээний бусад зардал	30,620,650.00	65,054,820.00

Архангай аймгийн Цахир сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

50	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,042,700.00	0
51	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,265,476.63	99,003,600.83
52	Бусад урсгал шилжүүлэг	18,864,100.00	700,000.00
53	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,539,100.00	0
54	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,325,000.00	700,000.00
55	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	42,401,376.63	98,303,600.83
56	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,401,376.63	98,303,600.83
57	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,450,000.00	10,555,500.00
58	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	4,450,000.00	10,555,500.00
59	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,450,000.00	10,555,500.00
60	Дотоод эх үүсвэрээр	4,450,000.00	10,555,500.00
61	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,450,000.00	10,555,500.00
62	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-4,450,000.00	-10,555,500.00
63	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0	0
64	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
65	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	449,946,100.00	395,692,829.17	54,253,270.83	87.9%
2	УРСГАЛ ЗАРДАЛ	449,946,100.00	395,692,829.17	54,253,270.83	87.9%
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	449,181,100.00	394,992,829.17	54,188,270.83	87.9%
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232,938,200.00	232,790,712.00	147,488.00	99.9%
5	Үндсэн цалин	232,938,200.00	232,790,712.00	147,488.00	99.9%
6	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,446,700.00	30,051,350.17	1,395,349.83	95.5%
7	Тэтгэврийн даатгал	22,129,100.00	20,733,750.17	1,395,349.83	93.7%
8	Тэтгэмжийн даатгал	2,329,400.00	2,329,400.00	0.00	100.0%
9	ҮОМШӨ-ний даатгал	1,863,500.00	1,863,500.00	0.00	100.0%
10	Ажилгүйдлийн даатгал	465,900.00	465,900.00	0.00	100.0%
11	Эрүүл мэндийн даатгал	4,658,800.00	4,658,800.00	0.00	100.0%
12	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,683,000.00	15,322,733.00	360,267.00	97.7%
13	Гэрэл, цахилгаан	3,583,000.00	3,222,733.00	360,267.00	89.9%
14	Түлш, халаалт	12,100,000.00	12,100,000.00	0.00	100.0%
15	Хангамж, бараа материалын зардал	33,505,400.00	33,504,350.00	1,050.00	100.0%
16	Бичиг хэрэг	5,545,400.00	5,545,400.00	0.00	100.0%
17	Тээвэр, шатахуун	19,000,000.00	19,000,000.00	0.00	100.0%
18	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,300,000.00	3,298,950.00	1,050.00	99.7%
19	Ном, хэвлэл	60,000.00	60,000.00	0.00	100.0%
20	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,800,000.00	2,800,000.00	0.00	100.0%
21	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,800,000.00	2,800,000.00	0.00	100.0%
22	Нормативт зардал	5,200,000.00	5,196,800.00	3,200.00	99.9%
23	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,200,000.00	5,196,800.00	3,200.00	99.9%
24	Эд хогшил, урсгал засварын зардал	11,120,000.00	11,120,000.00	0.00	100.0%
25	Багаж, техник, хэрэгсэл	8,400,000.00	8,400,000.00	0.00	100.0%
26	Урсгал засвар	2,720,000.00	2,720,000.00	0.00	100.0%
27	Томилолт, зочны зардал	6,500,000.00	6,500,000.00	0.00	100.0%
28	Дотоод албан томилолт	4,500,000.00	4,500,000.00	0.00	100.0%
29	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0%
30	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,344,300.00	9,616,564.00	2,727,736.00	77.9%
31	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,986,000.00	8,405,536.00	2,580,464.00	76.5%
32	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	700,000.00	700,000.00	0.00	100.0%
33	Даатгалын үйлчилгээ	100,000.00	54,450.00	45,550.00	54.4%
34	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	108,310.00	41,690.00	0.0%
35	Газрын төлбөр	348,300.00	348,268.00	32.00	99.9%
36	Бараа үйлчилгээний бусад зардал	100,443,500.00	50,890,320.00	49,553,180.00	50.6%
37	Бараа үйлчилгээний бусад зардал	100,443,500.00	50,890,320.00	49,553,180.00	50.7%
38	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	765,000.00	700,000.00	65,000.00	91.5%
39	Бусад урсгал шилжүүлэг	765,000.00	700,000.00	65,000.00	91.5%
40	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	765,000.00	700,000.00	65,000.00	91.5%
41	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	449,946,100.00	434,139,789.17	15,806,310.83	87.9%
42	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	0	0.00	72.7%

Архангай аймгийн Цахир сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

43	Улсын төсвөөс санхүүжих	0	0	0.00	87.9%
44	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	360,987,900.00	365,089,459.17	-4,101,559.17	72.8%
45	Орон нутгийн төсвөөс	360,987,900.00	365,089,459.17	-4,101,559.17	72.8%
46	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	88,958,200.00	69,050,330.00	19,907,870.00	149.5%
47	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	25,000,000.00	69,050,330.00	44,050,330.00	276.2%
48	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	63,958,200.00	0	0	100.0%
49	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	0	0	0	100.0%
50	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	0	0	0	100.0%
51	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	0	0	0	100.0%
52	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	0	0	0	100.0%
53	Гэрээт ажилтан	0	0	0	100.0%

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	гүйцэтгэл
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	20,568,681
2	УРСГАЛ ЗАРДАЛ	20,568,681
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,568,618
4	Хангамж, бараа материалын зардал	1,592,840
5	Тээвэр, шатахуун	1,592,840
6	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	655,841
7	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	655,841
8	Бараа үйлчилгээний бусад зардал	18,320,000
9	Бараа үйлчилгээний бусад зардал	18,320,000
10	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	20,568,681
11	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,568,681
12	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,820,000
13	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,748,681

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Цахир сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагаас, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Энхчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Цахир сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/8 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цахир сумын ЗДТГ нь Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн, харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах, Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах чиг үүрэг бүхий аймаг, сумын ТЕЗ-ийн харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд *"Иргэдэд төрийн үйлчилгээг хурдан шуурхай үзүүлэх, үйл ажиллагааны тасралтгүй удирдлагаар хангах, нутгийн захиргааны шийдвэр гаргах тогтолцоог дэмжих"* гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь тайлант онд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөөгүй, харин аймгийн Засаг даргын 2021 оны А/841 захирамжаар "аймгийн ТЕЗ-ийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг баталсныг 2022 оноос мөрдөж эхлэхээр байна. Уг баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн боловч тухайн

байгууллагын онцлог ажил гүйлгээ буюу мал амьтны гүйлгээг хэрхэн бүртгэх талаар нарийвчлан тусгаагүй байна.

Тайлант онд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2016-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторроос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цахир сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 449.9 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 1237.0 сая төгрөгөөр буюу 25.9 хувиар өсч материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт сая төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Өглөг	0,0	0.3	0.3	100
Авлага	0.2	42.3	42.1	99.8
Бараа материал	159.6	136.0	-23.6	-14.8
Үндсэн хөрөнгө	1237.0	1557.3	320.3	25.9
Нийт хөрөнгө	1396.8	1735.5	338.7	24.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1396.8	1735.5	338.7	24.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1396.8	1735.5	338.7	24.2

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Өглөг эхний үлдэгдэл өмнөх оноос 100 хувиар өссөн байна

- Авлагын эхний үлдэгдэл өмнөх оноос 99.9 хувиар өссөн байна.
- Бараа материалын үлдэгдэл 14.8 хувиар буурсан байна.

Бараа материалын данс нь 159.6 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 217.5 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 241.1 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 136.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 25.9 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 1,237.0 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 10.6 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 408.7 сая төгрөг нийт 419.3 сая төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгө шилжүүлсэний гарз 0.5 сая төгрөг, тайлант хугацаанд байгуулсан 98.5 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр тус тус буурч, 1,557.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнг 338.7 сая төгрөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт сая төгрөгөөр

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	366.9	424.9	58.0
Үндсэн үйл ажиллагааны орлого	47.7	69.1	21.4
Нэмэлт санхүүжилтийн орлого	8.3	20.6	12.3
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	340.3	408.7	68.4
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	113.6	113.6
Үйл ажиллагааны орлого	763.2	1,036.9	273.7
Цалин, шимтгэлийн зардал	254.6	263.0	8.4
Бусад бараа үйлчилгээний зардал	88.7	64.9	(23.8)
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16.5	9.9	(6.6)
Бараа үйлчилгээний бусад зардал	115.5	246.8	131.3
Урсгал шилжүүлэг	61.3	99.0	37.7
Хөрөнгө шилжүүлсэн			-
Үйл ажиллагааны зардал	536.60	683.6	147.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	226.60	353.30	126.7

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх урсгал үйл ажиллагааны санхүүжилт өмнөх оноос 58.0 сая төгрөгөөр өссөн байна. Харин үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өмнөх оноос 68.4 сая төгрөгөөр өссөн нь Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажлуудыг орлогод авч, бүртгэж тайлагнасантай холбоотой байна. Урсгал санхүүжилтээс 98.3 сая төгрөг хэмнэгдэж буцаан төвлөрүүлсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 398.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг анх нийт 7.9 сая төгрөгөөр нэмж, 406.6 сая төгрөгөөр хянаж баталжээ. Харин төсвийн тодотголоор нэмэгдүүлэн 449.6 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 449.9 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 424.9 сая төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 25.0 сая төгрөг төвлөрүүлэн нийт 449.9 сая төгрөгийн орлого, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлснээс 395.7 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 98.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь бараа үйлчилгээний урсгал зардлуудаас 98.3 сая төгрөг хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жил нэмэлт санхүүжилтээр Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 0.7 сая төгрөг, аймгийн ЗДТГ-аас өвс тэжээлийн нөөц бэлтгэхэд 14.5 цэрэг татлагын шатахуун, урамшууллын зардалд 0.1 сая төгрөг, ковид цах тахалтай холбоотойгоор иргэд ААНБ-аас хандиваар 4.8 сая, Хүүхэд гэр, залуучуудын хөгжлийн газраас 0.5 сая төгрөг нийт 20.6 сая төгрөгийг тус тус хүлээн авч тээвэр шатахууны зардалд 1.6 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 0.7 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 18.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Ковид цар тахлын тархалтыг бууруулах ажлын хүрээнд иргэд, ААНБ-аас 4.8 сая төгрөгийн мөнгөн хандивыг хүлээн авч, зориулалтын дагуу зарцуулжээ.

Тайлант онд тус байгууллага нь 100.0 сая төгрөгийн өртөг бүхий сумын төвийн авто замын их засварын ажил, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 43.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий инженерийн хийцтэй 2 худгийг үндсэн хөрөнгөнд бүртгэж, тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант хугацаанд удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий дараах ажил гүйлгээ гарсан байна.

Цахир сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/97 дугаар захирамжаар ЗДТГ-ын дансанд бүртгэлтэй цөм сүргийн хуц, эм хонь нийт 319 толгой малыг иргэн Г.Эрдэнэбаатарт 42.3 сая төгрөгөөр худалдан борлуулж төлбөрийг 2022 онд хүлээн авах гэрээ байгуулж авлага үүсгэсэн байна.

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 19 үндсэн зорилтын хүрээнд 102 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж,

дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг Сумын засаг даргаас 95.0 хувь гэж үнэлсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 449.9 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 395.7 сая төгрөгийг зарцуулж, 87.9 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнгийн талаарх судалгааг авч үзэхэд
 - Батлагдсан төсөвт зардлаас 98.3 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгож, батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна.
 - Суудлын автомашин ашиглалтын судалгаа: Тус байгууллага нь нийт 50.1 сая төгрөгийн анхны өртөг бүхий 2 автомашинтай, шатахууны зардалд 20.6 сая төгрөгийг зарцуулсан, орон тооны жолоочтой, жолоочийн цалинд 8.9 сая төгрөгийг олгожээ.
 - Бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цахир сумын ЗДТГ нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 149 мэдээллээс 146 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг хэрэгжүүлж, мэдээллийг хуулинд заасан хугацаанд тогтмол мэдээлж хэвших зөвлөмж хүргүүллээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад зөрчилтэй асуудал илрээгүй байна. Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар авч үзэхэд 98.0 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгож, орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй, харин бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн үйл ажиллагаанд шилэн дансанд оруулбал зохих 149 мэдээллээс 142 мэдээллийг хугацаанд нь, 7 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсанд 1 заалт бүхий зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

3.11. ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

- МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 42.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ. Аудитын явцад ажиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбоотой зөвлөмжийг хүргүүлэв.

Залруулагдаагүй алдаа зөрчил 42.3 сая төгрөг нь тогтоосон материаллаг байдал 4.5 сая төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.1. Албан шаардлага

Сумын засаг даргын 2021 оны 12 сарын 03-ны өдрийн А/97 захирамжийн дагуу иргэн Г.Эрдэнэбаатартай цөм сүргийн хуц, эм хонь нийт 319 толгой бог малыг 42.3 сая төгрөгөөр худалдан борлуулж төлбөрийг 2022 оны 03 сарын 01-ны дотор төрийн сангийн дансанд төвлөрүүлэхээр гэрээ байгуулж авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг зөрчсөн байна.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой.

Илрүүлэлт: Тус байгууллага нь тайлант онд нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг баталж мөрдөөгүй бөгөөд 2022 оноос аймгийн Засаг даргын захирамжаар баталсан баримт бичгийг мөрдөхөөр байна. Уг бодлогын баримт бичигт тус байгууллагын онцлог ажил гүйлгээ болох цөм сүргийн малын бүртгэлийг хэрхэн бүртгэх талаар нарийвчлан тусгаагүй нь ажиглагдлаа.

Зөвлөмж: Байгууллагын онцлог ажил гүйлгээ болох цөм сүргийн малын бүртгэлийг хэрхэн хөтлөх талаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгуулах саналыг боловсруулж аймгийн Төсвийн захирагчид хүргүүлж шийдвэрлүүлэх

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 06 сарын 01-ний дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oO-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Заглуулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Цахир сумын ЗДТГ	1	42.3	0	0	0	0	1	42.3	0	0
	Дүн	0	0	0	0	0	0	1	42.3	0	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	Цахир сумын ЗДТГ	0	0	0	0	0	0	1	0	0	0
	Дүн	0	0	0	0	0	0	1	0	0	0
	Нийт дүн	0	0	0	0	0	0	2	42.3	0	0